ХОВД  АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын ЕБ-ийн 7 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХОА-2025/031/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mnР Ховд хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 99013699 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Балжинням<br>Утас:99435309 Цахим хаяг: baljinnyamd@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.03.15. № 2/77

танай ______ -ны № ______ -т

ЖАРГАЛАНТ СУМЫН 7-Р
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.АЛТАНТУНГАЛАГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүх л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.1.3, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- *Заалны түрээсийн орлогын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж тайлан балансд тусгаагүй 13,880.9 мянга төгрөг,*
- *Сүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн санхүүжилтээс хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй 15,058.1 мянган төгрөг,*
- *Дотуур байрны хүүхдийн хоолны талон засвар ихтэй, хоолны талон бичсэн тогооч жирэмсний амралттай байх хугацаандаа бичсэн, 4,5,6-р сарын хоолны талон нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажаагүй, нүүрсний зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй 39,220.8 мянган төгрөг,*
- *Хүүхдийн хоол хүнсэнд хүүхдэд шим тэжээл болохгүй хүнс голдуу нийлүүлсэн, гарал үүслийн бичиг байхгүй, тогоочийн хоолны шим тэжээлийн өдөр тутмын тэмдэглэл хөтлөөгүй 8,885.0 мянга төгрөгийн зөрчил тус тус илэрсэн.*

**Асуудлыг онцолсон хэсэг**

Жаргалант сумын 7-р сургууль нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 103,667.6 мянга, улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 69,074.9 мянга, Боловсролын газраас сурах, хичээлийн хэрэглэгдэхүүнд 19,306.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж багш, сурагчдын ажиллах, суралцах нөхцөл сайжирсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад заалны түрээсийн орлого 13,880.9 мянган төгрөгийг тайланд тусгалгүй бэлнээр авч зарцуулсан нь материаллаг шинж чанарыг агуулсан болно.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 бүлэг 18 зорилт 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан Боловсролын газрын даргаар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **370,135,736.66** | **424,816,443.48** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 205,984,250.00 | 247,064,222.19 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 205,984,250.00 | 247,064,222.19 |
| **3121** | **Төгрөг** | 205,984,250.00 | 247,064,222.19 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 205,984,250.00 | 247,064,222.19 |
| **33** | **АВЛАГА** | 41,265.00 | 4,419.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 11,265.00 | 4,419.00 |
| **335** | **Бусад авлага** | 30,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 30,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 164,110,221.66 | 177,747,802.29 |
| **351** | **Түүхий эд материал** | 827,350.00 | 547,250.00 |
| 35130 | Эм боох материал | 827,350.00 | 547,250.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | 402,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,955,900.00 | 3,362,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 161,326,971.66 | 173,436,552.29 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,928,220.00 | 18,099,720.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 11,729,000.00 | 9,770,574.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,805,000.00 | 2,225,450.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 130,864,751.66 | 143,340,808.29 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,904,343,845.02** | **4,882,297,651.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,904,343,845.02 | 4,882,297,651.20 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,679,740,678.36 | 4,657,819,484.58 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,780,682,840.68 | 4,780,682,840.68 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (533,406,347.36) | (651,727,291.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 468,744,631.72 | 540,927,337.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (275,657,715.25) | (294,420,075.03) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 264,600,436.43 | 319,587,116.53 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (111,439,952.57) | (123,922,228.31) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 86,216,784.71 | 86,691,784.71 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 224,603,166.66 | 224,478,166.62 |
| 39301 | Програм хангамж | 18,900,000.00 | 18,900,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (18,420,833.34) | (18,545,833.38) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 224,124,000.00 | 224,124,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,274,479,581.68** | **5,307,114,094.68** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **12,378,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 12,378,000.00 |
| **413** | **Өглөг** | - | 12,378,000.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 12,600.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 12,365,400.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 12,365,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,274,479,581.68** | **5,294,736,094.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,274,479,581.68 | 5,294,736,094.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,523,546,409.40 | 1,523,546,409.40 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,523,546,409.40 | 1,523,546,409.40 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,595,646,254.82 | 2,615,902,767.82 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,595,646,254.82 | 2,595,646,254.82 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 20,256,513.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,155,286,917.46 | 1,155,286,917.46 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,274,479,581.68** | **5,307,114,094.68** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,876,246,457.30** | **4,222,627,349.85** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **51,499,909.30** | **217,279,049.85** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 51,499,909.30 | 217,279,049.85 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 51,499,909.30 | 217,279,049.85 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 808,200.00 | 5,430,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,150,000.00 | 99,491,099.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 47,541,709.30 | 112,357,950.85 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,824,746,548.00** | **4,005,348,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,619,494,000.00 | 3,796,622,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,619,494,000.00 | 3,796,622,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,648.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,648.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 205,101,900.00 | 208,725,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 205,101,900.00 | 208,725,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,014,232,405.40** | **4,200,437,809.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,014,232,405.40** | **4,200,437,809.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,915,575,917.40 | 3,951,070,907.26 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,027,773,037.36 | 2,856,519,564.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,411,015,661.00 | 1,825,302,984.00 |
| 210102 | Нэмэгдэл | 547,276,761.00 | 869,594,209.00 |
| 210104 | Урамшуулал | 69,480,615.36 | 161,622,371.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 250,401,519.85 | 352,627,832.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 173,159,470.35 | 243,148,158.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,371,702.39 | 28,559,099.63 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,244,561.91 | 15,296,590.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,691,860.63 | 12,901,287.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,933,924.57 | 52,722,695.38 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 175,379,912.00 | 187,936,194.13 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 40,964,012.00 | 49,841,380.13 |
| 210302 | Түлш, халаалт | 93,659,000.00 | 84,342,962.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 40,756,900.00 | 53,751,852.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,720,872.81 | 11,303,729.42 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,720,872.81 | 11,303,729.42 |
| **2105** | **Нормативт зардал** | 155,820,560.00 | 71,547,350.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,169,300.00 | 1,252,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 152,651,260.00 | 70,295,250.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 7,221,150.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 7,221,150.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,152,435.64 | 66,680,456.81 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 474,840.00 | 5,430,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,677,595.64 | 61,250,456.81 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 282,327,579.74 | 397,234,630.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,609,845.00 | 154,461,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 27,106,515.00 | 25,940,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 194,611,219.74 | 216,832,430.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 98,656,488.00 | 249,366,901.87 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 91,214,000.00 | 236,513,720.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 87,144,000.00 | 172,703,620.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,070,000.00 | 63,810,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7,442,488.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,442,488.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 12,853,181.87 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 12,853,181.87 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(137,985,948.10)** | **22,189,540.72** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 1,933,027.72 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 1,933,027.72 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (1,933,027.72) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(137,985,948.10)** | **20,256,513.00** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 1,523,546,409.40 | 1,155,286,917.46 | 2,731,283,323.76 | 5,410,116,650.62 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (6,276,000.00) | (6,276,000.00) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,523,546,409.40** | **1,155,286,917.46** | **2,725,007,323.76** | 5,403,840,650.62 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (129,361,068.94) | (129,361,068.94) |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,523,546,409.40** | **1,155,286,917.46** | **2,595,646,254.82** | 5,274,479,581.68 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,523,546,409.40** | **1,155,286,917.46** | **2,595,646,254.82** | 5,274,479,581.68 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,523,546,409.40** | **1,155,286,917.46** | **2,595,646,254.82** | 5,274,479,581.68 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 20,256,513.00 | 20,256,513.00 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,523,546,409.40** | **1,155,286,917.46** | **2,615,902,767.82** | 5,294,736,094.68 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,828,904,748.00** | **4,110,269,399.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,958,200.00** | **104,921,099.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,958,200.00 | 104,921,099.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,958,200.00 | 104,921,099.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 808,200.00 | 5,430,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,150,000.00 | 99,491,099.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,824,946,548.00** | **4,005,348,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,619,694,000.00 | 3,796,622,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,619,694,000.00 | 3,796,622,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,648.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,648.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 205,101,900.00 | 208,725,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 205,101,900.00 | 208,725,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,886,772,607.85** | **4,069,189,426.81** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,886,772,607.85** | **4,069,189,426.81** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,711,590,459.85** | **3,818,416,424.94** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,023,976,222.77 | 2,855,908,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 1,407,014,451.26 | 1,824,691,720.00 |
| 210102 | Нэмэгдэл | 547,276,761.07 | 869,594,209.00 |
| 210104 | Урамшуулал | 69,685,010.44 | 161,622,371.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 250,408,389.44 | 352,632,250.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 173,144,820.53 | 243,148,159.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,393,211.14 | 28,559,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,244,562.90 | 15,296,590.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,691,865.36 | 12,901,287.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,933,929.51 | 52,727,114.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 187,659,412.00 | 188,051,268.13 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 40,964,012.00 | 49,841,380.13 |
| 210302 | Түлш, халаалт | 105,938,500.00 | 84,458,036.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 40,756,900.00 | 53,751,852.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 74,900,700.00 | 70,703,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 74,900,700.00 | 70,703,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,000,000.00 | 7,821,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 7,821,150.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,025,795.64 | 95,066,778.81 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 808,200.00 | 33,536,322.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,217,595.64 | 61,530,456.81 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 147,619,940.00 | 248,233,578.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,394,340.00 | 218,782,678.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 27,225,600.00 | 29,450,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **175,182,148.00** | **250,773,001.87** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 167,739,660.00 | 237,919,820.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 167,739,660.00 | 174,109,720.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 63,810,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7,442,488.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,442,488.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 12,853,181.87 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 12,853,181.87 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | <u>(57,867,859.85)</u> | <u>41,079,972.19</u> |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (57,867,859.85) | 41,079,972.19 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 205,984,250.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 205,984,250.00 | 247,064,222.19 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,005,348,300.00 | 3,964,268,327.81 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,005,348,300.00 | 3,964,268,327.81 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,766,428,500.00 | 3,726,348,507.81 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,759,239,000.00 | 2,763,840,382.87 |
| 210101 | Үндсэн цалин | 1,786,273,600.00 | 1,732,146,585.87 |
| 210102 | Нэмэгдэл | 864,153,100.00 | 869,594,209.00 |
| 210104 | Урамшуулал | 108,812,300.00 | 162,099,588.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 369,527,000.00 | 352,632,250.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 251,278,500.00 | 243,148,159.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,562,100.00 | 28,559,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,781,100.00 | 15,296,590.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,781,100.00 | 12,901,287.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 59,124,200.00 | 52,727,114.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 200,625,700.00 | 188,051,268.13 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 49,545,000.00 | 49,841,380.13 |
| 210302 | Түлш, халаалт | 97,328,800.00 | 84,458,036.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 53,751,900.00 | 53,751,852.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 71,703,100.00 | 70,703,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 71,703,100.00 | 70,703,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,099,900.00 | 7,821,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,099,900.00 | 7,821,150.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 106,332,700.00 | 95,066,778.81 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,251,200.00 | 33,536,322.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 72,081,500.00 | 61,530,456.81 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 250,901,100.00 | 248,233,578.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 221,450,200.00 | 218,782,678.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 29,450,900.00 | 29,450,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 238,919,800.00 | 237,919,820.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 238,919,800.00 | 237,919,820.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 175,109,700.00 | 174,109,720.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 63,810,100.00 | 63,810,100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,005,348,300.00 | 4,005,348,300.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,796,622,700.00 | 3,796,622,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 3,796,622,700.00 | 3,796,622,700.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 208,725,600.00 | 208,725,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 208,725,600.00 | 208,725,600.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **205,984,250.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **247,064,222.19** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82,473.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,458.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 1 алдааг[1] аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- *Санхүүгийн тайланд үнэ төлбөргүй ирсэн хөрөнгө данс бүртгэлд тусгаж тайлагнаагүй 5,458.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн тайланд залруулсан*

Залруулагдаагүй 77,014.9 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 77,014.9 мянган төгрөгийн 4 зөрчил[2] илэрснээс 28,939.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 39,220.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 8,855.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1**. ***Илрүүлэлт:*** *Заалны түрээсийн орлогын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж тайланд тусгаагүй 13,880.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцээгүй.*

**5.1.2** ***Илрүүлэлт:*** *Тайлант онд хэрэглэсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 15,058.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” заалттай нийцэхгүй байна.*

***Шийдвэрлэсэн нь***: *Төлбөрийн акт тогтоосон*

### 5.2 Албан шаардлага

***Илрүүлэлт:*** *Дотуур байрны хүүхдийн хоолны талон засвар ихтэй, талон бичсэн тогоочийн нэр зөрүүтэй, 4,5 дугаар сард тогооч нь жирэмсний амралтай байх хугацаандаа бичсэн, 4.5.6-р сарын хоолны талон, хүнсний тайлан, нүүрсний тайлан зарцуулалт нь нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажаагүй, удирдлагын дотоод хянал сул байгаа 39,2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

*хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй.*

***Шийдвэрлэсэн нь:*** *Албан шаардлага бичих*

***Илрүүлэлт:*** *Сургуулийн захирал, нягтлан бодогч нар нь заалны түрээсийн орлого, зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүйгээс биеийн тамирын багш, нярав, манаач нар заалны түрээсийн орлогыг хувь дансаар авч зарцуулсан, санхүүгийн тайланд тусгаагүй, бэлэн мөнгө зарцуулах журмыг зөрчсөн зэрэг ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.*

*Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 2.5-д Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар зарлага хийхдээ зарцуулалтын эрхийн хүрээнд зөвшөөрөгдсөн төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэх бөгөөд Төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн /цаашид "ЖМС" гэх/ хязгаарыг дагаж мөрдөнө, 7.2-д Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна, 8.1-д Төсвийн байгууллага нь мөнгөн касс, үнэт цаасны зарцуулалт, хадгалалтын ажиллагаанд хяналт, шалгалт явуулах, өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгууллагын даргын тушаал, шийдвэрээр байгуулж ажиллуулна гэсэн заалттай нийцээгүй*

***Шийдвэрлэсэн нь:*** *Хариуцлага тооцуулах албан шаардлага бичих*

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**5.3.1 Хүнсний зарцуулалттай холбоотой**

***<u>Илрүүлэлт:</u>*** *Хүүхдийн хоол хүнсэнд шим тэжээл болохгүй хүнс нийлүүлсэн, хүнсний гарал үүслийн бичиг байхгүй хоол хүнс нийлүүлсэн, өдөр тутмын технологийн карт хөтлөөгүй 8,855.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй*

*<u>Өгсөн зөвлөмж:</u> Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа материал, хоолны цэсэд шат шатны хяналтыг хэрэгжүүлж ажиллах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгө бүртгээгүй | 1 | 5,458,0 | 1 | 5,458,0 | | | 1 | 5,458.0 | | | | |
| **ДҮН** | **1** | **5,458.0** | **1** | **5,458.0** | | | **1** | **5,458.0** | | | | |

### *6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс: Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хариуцлага тооцох** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Заалны түрээсийн орлогын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж тайлан балансt тусгаагүй | 1 | 13,880.9 | 1 | 13,880.9 | | | | | | |
| Сүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн санхүүжилтээс хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй | 1 | 15,058.1 | 1 | 15,058.1 | | | | | | |
| Дотуур байрны хүүхдийн хоолны талон засвар ихтэй, 4.5.6-р сарын хоолны талон, нүүрсний тайлан зарцуулалт нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажаагүй | 1 | 39,220.9 | | | 1 | 39,220.9 | | | | |
| Сургуулийн захирал, нягтлан бодогч нар нь заалны түрээсийн орлого, зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүйгээс биеийн тамирын багш, нярав, манаач нар 13,9 сая төгрөгийн заалны түрээсийн орлогыг хувь дансаар авч зарцуулсан, | 1 | | | | | | | | 1 | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүүхдийн хоол хүнсэнд шим тэжээл болохгүй хүнс нийлүүлсэн, хүнсний гарал үүслийн бичиг байхгүй хоол хүнс нийлүүлсэн, өдөр тутмын технологийн карт хөтлөөгүй | 1 | 8,855.0 | | | | | 1 | 8,855.0 | 1 | |
| | **5** | **77,014.9** | **2** | **28,939.1** | **1** | **39,220.9** | **1** | **8,855.0** | **1** | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР** **Х.БОЛДБААТАР**

**2025.03.15**

**АУДИТЫН МЕНЕЖЕР** **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**2025.03.15**

**ГЭРЭЭТ АУДИТОР** **Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ**

**2025.03.15**

ОА-2025/031/НА-СТА-ТШ3